

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Сайншанд сум

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Биелэлт	Үнэлгээ
Зорилт-1: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ				
1.	Арга хэмжээ 1.1 “Эрүүл Монгол Хүн” өглөөний дасгалыг тогтмол явуулна.	Хамрагдагчдын тоо	Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор 7 хоног бүрийн 5 өдөр өглөө 06 ⁰⁰ -08 ⁰⁰ цагийн хооронд шугаман бүжиг хичээллэж, давхардсан тоогоор 2648 иргэн хамрагдаж хичээллэгсдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57,5 хувиар ессөн үзүүлэлтэй байна.	100
2.	Арга хэмжээ 1.2 Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж спорт заалаар үйлчилж нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	Гэрээ байгуулсан аж ахуй нэгж, албан байгууллагын тоо	2025 оны эхний хагас жилд Спортын холбоодтой хамтран зохион байгуулсан Дорноговь опен Жюу жицуугийн Олон Улсын нээлттэй тэмцээнд 3 улсын, 29 клуб, 500 тамирчин, БНХАУ-ын “Эрээн хот опен” Олон улсын тэмцээнд 5 улсын 45 багийн 600 тамирчин, Говийн бүсийн шатарын аварга шалгаруулах тэмцээнд 4 аймаг, 240 тамирчин, 19 дэх удаагийн улсын аварга шалгаруулах пауэрлифтингийн тэмцээнд 18 аймаг, 9 дүүргийн 200 тамирчин, U23 залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 20 багийн 250 тамирчин тус тус хамрагдсан байна. Мөн чөлөөт бөх, жudo, шатар, даам, дугуй, бокс, шагайн харваа, нийтийн бүжиг, үндэсний бөх, волейболын ёсверийн болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, сагсан бөмбөг, говь гаяс лиг, волейболын хөгжлийн лиг, шинэ эхлэл хүүхдийн лигийн тэмцээнүүд зохион байгуулагдсан. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 секц дугуйланд 12819 ёсверийн болон насанд хүрэгчид хичээллэж, 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хийж давхардсан тоогоор 6202, шугаман бүжгийг	100

			сонирхон хичээллэгсэд давхардсан тоогоор 2648, спортын үйл ажиллагаанд 12550 иргэн тус тус хамрагдсан.		
Зорилт-2: Аймгийн засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ					
3.	Арга хэмжээ 2.1 "Унадаг дугуй" арга хэмжээг хэрэгжүүлэх	Унадаг хичээллэгсийн нэмэгдэнэ.	дугуйгаар тоо	<p>Аймгийн дугуйн спортын, аялалын "Хулан" клубээс санаачлан унадаг дугуйг нийтийн хэрэглээ болгохоор аймгийн хэмжээнд судалгаа хийж, судалгааны дүнд үндэслэн ойрын дугуйн аялал, зугаалгыг жил бүр явуулж хэвшсэн. Аймгийн хэмжээнд нийт 270 хүн унадаг дугуйг хэрэглээний болон спортын зориулалтаар тогтмол хэрэглэж дугуйн спортоор хичээллэгсийн тоо өмнөх оны мөн үеэс 80 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан "Сайншанд цом-2025" ёсвériйн дугуйчдын аварга шалгаруулах тэмцээнд 130 тамирчин, Уулын дугуйн ёсвériйн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 60, Хүүхдийн спортын 8 дугаар их наадмын анхан шатны шигшээ тэмцээнд 75, дугуйн спортын улсын аварга шалгаруулах тэмцээнд 18 тамирчин оролцож 2 хүрэл медаль хүртэж багийн дунгээр 5-р байр эзэлсэн амжилт үзүүлсэн. 2025 оны хагас жилийн байдлаар хичээллэгсийн тоо 75, сонирхогчдын тоо 270 болж өссөн. Хүүхдийн спортын VIII их наадамд дугуйн спортын төрлөөр 4 тамирчин, 1 дасгалжуулагчийн хамт оролцож нийлбэр дунгээр 8 дугаар байрыг эзэлсэн.</p>	100
4.	Арга хэмжээ 2.2 Үндэсний спортын төрлийг хөгжүүлэхэд спортын холбоо, клубүүдтэй хамтарч ажиллах	Хамтран ажилласан холбоо, клубүүдийн тоо		<p>Үндэсний спортын төрлүүдийг сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор аймгийн Шагайн холбоотой хамтран аймгийн аварга шалгаруулах, ахмадын аймгийн аварга шалгаруулах шагайн харвааны тэмцээн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Үндэсний шагайн харвааны тэмцээний "Цомын эзэн" Дорноговь аймгийн "Номт даншиг хетрик" группт хүндэтгэл үзүүлэх тэмцээнд 8 аймгийн 60 багийн 450 харваачид, "Говийн бүсийн шинийн наймны харваанд 69 багийн 550 харваачид тэмцээн, Монгол цэргийн өдөр", Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан улс, аймгийн алдар цолтой 128 бөхийн барилдааныг тус тус зохион байгуулсан.</p> <p>Ахмад харваачид, залуучууд, шагай сонирхогчдыг бэлтгэл сургуулилт хийх орчинг бүрдүүлж Биеийн тамир, спортын газрын Спорт цогцолборт шагай харваачдад бэлтгэлийн өрөө гарган өгч өдөр бүр тогтмол хичээллэж хэвшсэн. Мөн үндэсний бөхийн барилдаан зохион</p>	100

			байгуулагдах бүрт бөхийн эд хэрэглэлээр ханган ажилласан. Сумдуудад иргэдийн дунд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Адуучин”, “Сурын харваа”, “Буухиа тэмцээн”, “Шагайн харваа”, “Халз харваа” зэрэг тэмцээнийг иргэдийн дунд зохион байгуулж 1086 иргэд оролцсон. Соёл спортын ордонтой харьяа сумдуудад (8 сум, Сайншанд сумын 5-р баг) үндэсний бөхийн дугуйландаа дахардсан тоогоор 4074, Шагайн харвааны дугуйландаа 833, үндэсний сурын дугуйландаа 313 хүүхэд хичээллэж, нийт давхардсан тоогоор 5220 иргэд, хүүхэд залуучууд тогтмол хамрагдаж байна.	
5.	Арга хэмжээ 2.3 Спортын ордон байгуулахад ордонд ажиллах нийтийн биеийн тамирын өс, мэргэжлийн багш, дасгалжуулагч нарыг бэлтгэх ажилд хамтран ажиллана. /Алтанширээ сум/	Арга зүйч, дасгалжуулагчдын тоо	Аймгийн ИТХ-ын 2024 оны 03/02 дугаар аймгийн 2025 оны төсвийг батлах тухай тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Алтанширээ суманд Соёл спортын ордон барих 2,008,000.0 төгрөгийн төсөв батлагдаж "Эйбол ХХК" компанийтай гэрээ байгуулан барилгын гүйцэтгэл 70%-тай байна.	70
6.	Арга хэмжээ 2.4 Улс, бүсийн тэмцээнийг орон нутагтаяа зохион байгуулна.	Зохион тэмцээний тоо байгуулсан	Спортын холбоодтой хамтран зохион байгуулсан Дорноговь оцен Жююжицуний Олон Улсын нээлттэй тэмцээнд 3 Улсын, 29 клуб, 500 тамирчин, БНХАУ-ын “Эрээн хот оцен” Олон Улсын тэмцээн 5 Улсын 45 багийн 600, Говийн бусийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн 4 аймаг 240 тамирчин, 19 дэх удаагийн Улсын аварга шалгаруулах Пауэрлифтингийн тэмцээн 18 аймаг, 9 дүүргийн 200, U23 залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 20 багийн 250 тамирчин хамрагдсан. Мөн чөлөөт бөх, жүдо, шатар, даам, дугуй, бокс, шагайн харваа, нийтийн бүжиг, үндэсний бөх, сагсан бөмбөг, волейболын ёсвériйн болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 1521, Говь гаяс лиг 17 багийн 230 тамирчин, Хөгжлийн лигийн тэмцээнд 14 багийн 196, Ирээдүй хүүхдийн лигийн тэмцээнд 7 багийн 288, нийт 714 тамирчин оролцож, 8730 үзэгчтэй зохион байгуулсан.	100
7.	Арга хэмжээ 2.5 ёсвériйн шигшээ багийн төрлийн тоо, медалийн чанарыг ахиулна.	Шигшээ багийн төрлийн тоо, медалийн үзүүлэлт	Тус аймгийн ёсвériйн шигшээ багийн тамирчид Монгол Улсын ёсвériйн аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээнд 1 алт, Азийн аварга шалгаруулах жююжицуний тэмцээнд 1 мөнгө, Жююжицуний Дорноговь оцен Олон Улсын тэмцээн 20 алт, 29 мөнгө, 18 хүрэл, Эрээн оцен Олон Улсын тэмцээн 10 алт, 9 мөнгө, 6 хүрэл, Улсын аварга	100

			шалгаруулах тэмцээн 11 алт, 15 мөнгө, 4 хүрэл, Монгол Улсын аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээн 1 алт, Олон хотын жудо бөхийн аварга шалгаруулах тэмцээн 1 мөнгө, Зүүн бүсийн аварга шалгаруулах ёсвөр үеийн жудо бөхийн тэмцээн 3 алт, 1 мөнгө, 4 хүрэл, Боксийн Олон Улсын тэмцээн 1 алт, 1 мөнгө, 2 хүрэл, Насан хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 1 алт, 1 мөнгө, 2 хүрэл, Залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээн 1 алт, 2 мөнгө, 1 хүрэл, Азийн аварга шалгаруулах тэмцээн 1 алт, Олон Улсын Чансаа тогтоох тэмцээн 4 алт, Улсын ёсверийн аварга шалгаруулах тэмцээн 2 мөнгө, ёсверийн шатрын багийн дүнгээр мөнгө, ёсврийн улсын аварга шалгаруулах 100 буудалт даамын тэмцээнд 2 алт, 2 мөнгө, 2 хүрэл, Зүүн бүсийн аварга шалгаруулах 100 буудалт даамын тэмцээнд 5 алт, 6 мөнгө, 8 хүрэл, Улсын аварга шалгаруулах дугуйн спортын тэмцээн 2 хүрэл нийт 60 алт, 70 мөнгө, 49 хүрэл медаль хүртсэнээр Олон улс, бус, орон нутгийн чанартай 16 тэмцээнд аймгийн баг тамирчид оролцож амжилтын чанараа өмнө оныхоос 58%-иар ахиулсан байна.	
--	--	--	---	--

Зорилт-3: Аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээ

8.	Арга хэмжээ 3.1 Хүн амын хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор спортын холбоо, клубүүдтэй хамтарч ажиллах	Хамтын ажиллагаатай спортын холбоо, клубүүд	<p>“Сайншанд марафон-2025” арга хэмжээнд нийт 400 иргэн, Говийн бүсийн “Иргэдийн спортын их наадам”-д 4 аймгийн 600 гаруй тамирчин спортын 7 төрлөөр өрсөлдөж, хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажил, арга хэмжээнд нийт 1648 иргэд хамрагдсан.</p> <p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 секц дугуйланд 12819 ёсверийн болон насанд хүрэгчдийг хичээллүүлж, 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хийлгэж давхардсан тоогоор 6202, шугаман бүжгийн сонирхон хичээллэгсэд давхардсан тоогоор 2648 иргэд, спортын үйл ажиллагаанд 12550 иргэнийг хамруулсан.</p>	100
9.	Арга хэмжээ 3.2 Аймгийн хэмжээний лигийн тэмцээнүүдэд /Сагсан бөмбөг, Воллейбол гэх мэт/ зохион байгуулалтад	Хамтран ажилласан лигийн хэмжээний тэмцээн уралдааны тоо	Спортын холбоодтой хамтран Говь гаяс лигийн тэмцээнд 17 багийн 230 тамирчин, Хөгжлийн лиг 14 багийн 196, Ирээдүй хүүхдийн лиг 7 багийн 288 тамирчин оролцож 8730 үзэгчтэйгээр зохион байгуулсан.	100

	хамтран оролцох			
10.	Арга хэмжээ 3.3 Хөдөлгөөн эрүүл мэнд дэд хөтөлбөрийг цаашид хөгжүүлэх, сурталчлах	“Хөдөлгөөн эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Тус газар Эрүүл мэндийн газартай хамтран Хийн дасгалын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, сурагчдын дундах флаш моб тэмцээн, Ажлын байрны түмэн дасгал, Говийн бүсийн Иргэдийн спортын их наадам, Сайншанд марафон, бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг зохион байгуулж нийт 1188 тамирчин хамрагдсан.	100
11.	Арга хэмжээ 3.4 Мэргэжлийн спортыг дэмжиж, чадвар, дээшлүүлэх	Баг тамирчдын амжилт, медалийн чанар	Тус аймгийн тамирчид тив, дэлхий, улсын чанартай тэмцээн уралдаанаас 60 алт, 70 мөнгө, 49 хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан. Мэргэжлийн спортыг дэмжин аймаг орон нутагтаа Олон улсын 2, аймгийн аварга шалгаруулах 10, залуус, хүүхэд багачуудын дунд сагсан бөмбөг, волейболын төрлөөр 3 удаагийн лигийн тэмцээнийг зохион байгуулж 714 тамирчин 8730 үзэгчтэйгээр зохион байгуулагдлаа. Хүүхдийн спортын VIII их наадамд Дорноговь аймгаас 13 төрлөөр 122 тамирчин 13 дасгалжуулагчийн хамт оролцож чөлөөт бөх 1 хүрэл, жudo бөх 1 хүрэл, модон барилдаан 1 мөнгө, бокс 1 алт, 1 мөнгө 4, шатар 1 алт, волейбол 4-р байрт шалгарч нийт 10 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.	100
12.	Арга хэмжээ 3.5 Үндэсний спортыг дэмжих	Хичээллэгчдийн тоо, амжилт (Бөх, сур, шагайн харваа)	Үндэсний спортын төрлүүдийг сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор аймгийн Шагайн холбоотой хамтран энэ оны 01 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагайн харвааны тэмцээнийг зохион байгуулж 8 аймгийн 60 багийн 450 харваач, 03 дугаар сард "Говийн бүсийн сар шинийн харваанд 69 багийн 550, ахмадын аймгийн аварга шалгаруулах шагайн харвааны тэмцээнд 70 харваач тус тус оролцож, байгууллагын цахим хуудаст мэдээллийг тухай бүр байршуулан ажилласнаар иргэдийг үндэсний спортоор хичээллэх, монгол бахархлыг бий болгон ажилласан. Тус газрын Спорт цогцолборт шагай харвааны өрөө байрлаж, ахмад харваачид, залуучууд, шагай сонирхогчид бэлтгэл сургуулилт хийх орчинг бүрдүүлж, үндэсний бөхийн барилдаанд бөхийн эд хэрэглэлээр ханган ажилласан. Сумдуудад иргэдийн дунд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Адуучин", "Сурын харваа", "Буухиа тэмцээн", "Шагайн харваа" зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж хэвшсэн. Соёл спортын ордонтой харьяа сумдуудад (8 сум, Сайншанд сумын 5-р баг) үндэсний бөхийн дугуйланд 126, Шагайн харвааны дугуйланд 120, үндэсний сурын дугуйланд 30 хүүхэд тогтмол хичээллэж байна. Нийт	100

			хичээллэгч хүүхдийн тоо 276 байна. Үндэсний спорт болон бусад спортын төрлөөр улс болон тив дэлхийн чанартай тэмцээн уралдаанд медальт байр эзэлсэн тамирчдад жилийн эцэст аймгийн Засаг даргын захирамжийн дагуу жил бүр мөнгөн урамшуулалт олгож хэвшсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн цомын эзэн Дорноговь аймгийн "НОМТ ДАНШИГ ХЭТТРИК ГРУПП"-ийн нэрэмжит тэмцээнд Б.Баттулга ахлагчтай "Номт даншиг" баг дэд байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн.	
13.	Арга хэмжээ 3.6 "Дорноговь Бага олимп" спортын арга хэмжээг зохион байгуулах	Спортын төрөл, зохион байгуулсан тэмцээний тоо	"Дорноговь бага олимп" спортын наадмыг 09 дүгээр сарын 17-21 өдөр зохион байгуулан ажиллахаар төлөвлөж байна.	70
Зорилт-4:Биеийн тамир, спортын тухай хуулийн хүрээнд:				
14.	Арга хэмжээ 4.1 Аймгийн Засаг даргын дэргэдэх ёсвériйн шигшээ багийг спортын 10-аас дээш төрлөөр зохион байгуулан сургалт дасгалжуулалт явуулах	Спортын төрлийн тоо, хичээллэгчдийн тоо	Тус газар 2025 онд 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан спортын 12 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, бокс, чөлөөт бөх, жүдо бөх, жюү жицу, кудо бөх, даам, хөлбөмбөг, хөнгөн атлетик, дугуй, гандбол) сургалт, дугуйлан хичээллүүлж, аймгийн ёсвөр үеийн 12 шигшээ багт 560 гаруй тамирчид тогтмол хичээллэж байна. 2025 онд улсын төсвөөс батлагдсан хөтөлбөрийн хүрээнд эхний хагас жилийн байдлаар нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр 16 арга хэмжээ зохион байгуулж, 35,265,667 дэмжлэг үзүүлсэн.	100
15.	Арга хэмжээ 4.2 Бус, улс, олон улсын чанартай тэмцээн уралдаанд бэлтгэн оролцох	Оролцогчдын тоо, амжилт	Монгол Улсын ёсвériйн аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээнд 1 алт, Азийн аварга шалгаруулах жюү жицуний тэмцээнд 1 мөнгө, Жюү жицуний Дорноговь опен Олон Улсын тэмцээн 20 алт, 29 мөнгө, 18 хүрэл, Эрээн опен Олон Улсын тэмцээн 10 алт, 9 мөнгө, 6 хүрэл, Улсын аварга шалгаруулах тэмцээн 11 алт, 15 мөнгө, 4 хүрэл, Монгол Улсын аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээн 1 алт, Олон хотын жүдо бөхийн аварга шалгаруулах тэмцээн 1 мөнгө, Зүүн бүсийн аварга шалгаруулах ёсвөр үеийн жүдо бөхийн тэмцээн 3 алт, 1 мөнгө, 4 хүрэл, Боксийн Олон Улсын тэмцээн 1 алт, 1 мөнгө, 2 хүрэл, Насан хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 1 алт, 1 мөнгө, 2 хүрэл, Залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээн 1 алт, 2 мөнгө, 1 хүрэл, Азийн аварга шалгаруулах тэмцээн 1 алт, Олон Улсын Чансаа тогтоох тэмцээн 4 алт, Улсын ёсвériйн аварга шалгаруулах тэмцээн 2 мөнгө, ёсвériйн шатрын багийн дүнгээр мөнгө, ёсвériйн улсын аварга шалгаруулах 100 буудалт даамын тэмцээнд 2 алт, 2 мөнгө, 2 хүрэл,	100

			Зүүн бусийн аварга шалгаруулах 100 буудалт даамын тэмцэнд 5 алт, 6 мөнгө, 8 хүрэл, Улсын аварга шалгаруулах дугуйн спортын тэмцээн 2 хүрэл нийт 60 алт, 70 мөнгө, 49 хүрэл медаль хүртсэнээр Олон улс, бүс, орон нутгийн чанартай 16 тэмцээнд аймгийн баг тамирчид оролцож амжилтын чанараа өмнө оныхоос 58%-иар ахиуллаа. Тамирчдын бэлтгэлийг ханган наадам, тэмцээнд оролцуулах, амжилтыг нэмэгдүүлэх зорилгоор Говь гаяс лиг 17 багийн 230 тамирчин, Хөгжлийн лигийн тэмцээнд 14 багийн 196, Ирээдүй хүүхдийн лигийн тэмцээнд 7 багийн 288 тамирчин, 8730 үзэгчтэй тус тус зохион байгуулсан.	
Зорилт-5: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах.				
16.	Арга хэмжээ 5.1 Биеийн тамир, спортын тайлан мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх	Цаг үеийн болон улирал, хагас, бүтэн жилийн жилийн тайлан, шаардлагатай судалгаа мэдээллийг гаргах	Эхний хагас жилийн байдлаар Биеийн тамир, спортын улсын хороо болон аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Биеийн тамир, спортын улсын хороонд 4 тайлан, 1 судалгаа, аймгийн Засаг даргын Тамгийн газарт 3 тайлан, 4 судалгаа, Орон нутгийн өмчийн газарт 4 тайлан, 1 судалгаа, төрийн албаны салбар зөвлөлд 1 тайлан, бусад байгууллагууд руу 1 тайлан, 6 судалгааг заасан цаг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.	100
17.	Арга хэмжээ 5.2 Холбогдох дээд шатны байгууллагаас ирүүлсэн үүрэг, чиглэлийг цаг тухай бүрт биелүүлж ажиллах.	Харьяа хэлтэс, тасагт шилжүүлэн үүрэг чиглэлийг биелүүлэн ажиллах.	<p>Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас эхний хагас жилийн байдлаар 24 албан бичиг, 1 захирамж, 1 албан даалгавар ирүүлснээс үүрэг чиглэл өгсөн 7, Биеийн тамир, спортын улсын хорооноос 30 албан бичиг, 3 тушаал шийдвэр ирүүлснээс 13 чиглэл үүрэг даалгавар, аймгийн ОНӨГ-аас 7 албан бичиг ирүүлснээс хөрөнгө цахим бүртгэлд бүртгэх, зурагжуулах, орон нутгийн өмчийн болон түрээсийн гэрээ байгуулах, гэрээ дүгнэх тайлан мэдээ ирүүлэх зэрэг үүрэг чиглэл өгснийг заасан хугацаанд нь цахимд бүртгэлжүүлж, гэрээ байгуулан дүгнүүлж аяны хүрээнд хийж хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлтийн дагуу хийж гүйцэтгэсэн тайланг албан бичгээр хүргүүлж шийдвэрлэлтийг бүрэн хангаж ажилласан. Бусад байгууллага, холбоодоос 59 албан бичиг хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.</p> <p>Биеийн тамир, спортын улсын хороо болон аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу хийгдсэн ажил Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу цэрэг татлагын байр бэлтгэн байраар бүрэн хангаж, мөн аймгийн Засаг даргын А/270 захирамж, 2023 оны 01 албан даалгавар, 	70

		<p>Засгийн газрын 106 дугаар тогтоолын дагуу “Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн соёлыг дээшлүүль” 3 сарын аяныг зохион байгуулсан байгууллагын архивт хадгалагдаж байгаа 2013-2024 оны баримтад нягтлан шалгалт хийж Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийхээр данс бүртгэлээ батлуулж байнга хадгалах 2013-2018 оны 119 боть баримтыг цахим болгон ашиглалтын болон мастер хувь болгон цаасан болон цахим архиваа Төрийн архивт шилжүүлэн ёгсөн. Мөн аяны хүрээнд байгууллагын архив хадгалагдаж байгаа түр 260 хн, 70 жил хадгалагдах 68 хн, байнга хадгалагдах 57 боть, барилгын зураг төслийн 6 харйцаг баримтад дугаар хаяг хийж, архивын өрөөний цонхыг хар хөшигтэй болгож, зориулалтын байр болгон тохижуулж, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 4 гарын авлага бэлтгэн аяныг амжилттай зохион байгуулж албан даалгавар, Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг 100% ханган ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын үүрэг чиглэлийн дагуу “Их.govийн тэмээ-2025” арга хэмжээний зохион байгуулалтад байгууллагын 22 албан хаагч 1 өдөр ажиллаж тэмээн поло арга хэмжээг шүүн зохион байгуулалтаар ханган ажилласан. Мөн Говийн бүсийн Засгийн газрын хуралдаан зохион байгуулагдахад Биеийн тамир, спортын цогцолборын байрыг бэлтгэн цэвэрлэгээ үйлчилгээ зохион байгуулалтын ажлын хэрэгжүүлэн ажилласан байна. - Биеийн тамир, спортын улсын хорооноос ирүүлсэн 3 стандартын төсөлд санал оруулж, 3 тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахдаа Улсын хорооноос зохион байгуулсан “хүн амын бие бялдарын түвшин тогтоох сорил”-ын арга хэмжээг 5 сургуулийн спортоор хичээллэдэг хүүхэд, багш дасгалжуулагч нарыг оролцуулан 500 гаруй хүнийг хамруулж, “Говийн бүсийн иргэдийн спортын наадам”-ыг говийн 4 аймгийн хэмжээгээр 500 гаруй хүний 	
--	--	--	--

			оролцоотойгоор 2 өдөр амжилттай зохион байгуулж, Хүүхдийн спортын наадамд 122 тамирчин, 13 дасгалжуулагч 13 нэр төрлөөр амжилттай оролцсон.		
18.	Арга хэмжээ 5.3 Биеийн тамир, ажилтнуудын баталгааг сайжруулах хетелберийг хэрэгжүүлэх.	Нийгмийн спортын хангаж, дэд	Батлагдсан төлөвлөгөөний дагуу албан хаагчдын "Нийгмийн баталгаа, сургалтын хетелбөр"-ийг хэрэгжүүлэх	2025 онд "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хетелберийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г 24 заалтаар гаргаж ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Нийт албан хаагчдад ур чадварын, зэргийн нэмэгдэл, хоолны зардал, орон нутгийн нэмэгдэл, "Цагаан сар" баяраар 14 ахмад, эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан эмэгтэй албан хаагчдад тусгай хетелберийн дагуу хүндэтгэл үзүүлж бэлэг дурсгалын зүйл гардуулах арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Ажилтнуудын сайн дурын үндсэн дээр байгуулгдсан "Хамтын сан"-гаас шинэ орон сууцанд орсон 1, шинээр хүүхэдтэй болсон 1 албан хаагчид тус бүр 100,000 төгрөг тусlamж дэмжлэг үзүүлсэн. Гэр болон галлагаатай байшинд амьдардаг 9 албан хаагчдад түлээ, нүүрс авахад 1,350,000 төгрөгийн тусlamж үзүүлсэн. Улаанбаатар хотод нарийн мэргэжлийн эмнэлэгт үзүүлж онош тодруулах, ар гэрийн гачигдал, гэр бүлийн гишүүдээ асрахаар гаргасан 13 албан хаагчид цалинтай чөлөө олгож, ажлын бус цагаар болон амралтын өдрөөр ажилласан давхардсан тоогоор 17 албан хаагчдыг нөхж амраасан.	100
19.	Арга хэмжээ 5.4 Байгууллагын сургалтын хетелбөр батлаж, хэрэгжүүлэх		Байгууллагын ажилчид, албан хаагчдыг чадавхижуулах мэдлэгийг дээшлүүлэх сургалтын хетелбөр батлагдсан байна.	Тус газраас 2025 онд мэдвэл зохих хууль тогтоомжийн, албан хаагчдыг хөгжүүлэх сургалт гэсэн 2 чиглэл, 26 сэдвээр сургалтын төлөвлөгөө баталж, сар бүр 2 сургалт зохион байгуулан ажиллаж байна. БТСУХорооноос зохион байгуулсан мэргэшүүлэн сургалтанд 1, Үндэсний бөхийн холбоноос зохион байгуулсан сургалтанд 1 албан хаагч тус тус хамрагдсан.	100
20.	Арга хэмжээ 5.5 Байгууллагын дотоод хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах		Байгууллагын дотоод хяналт шалгалтыг холбогдох журмын дагуу хагас, бүтэн жилээр зохион байгуулсан байна.	Байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлыг эхний хагас жилийн байдлаар удирдамж гарган шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна	70

21.	Арга хэмжээ 5.6 Улс болон олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах, их наадмын тэмцээнээс медаль хүртсэн баг тамирчид, багш дасгалжуулагчдад мөнгөн урамшуулалт олгох.	Журманд заасан шалгуурыг хангасан баг, тамирчдын тоо, амжилт	Дорноговь аймгийн Засаг даргын 2021 оны А/171 дүгээр захирамжаар “Өсвөр үе, залуучуудын шигшээ баг”-ийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн дэмжих арга хэмжээг батлан, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн тамирчид, бэлтгэл сургуултыг ханган оролцуулсан дасгалжуулагчдыг 35,265,667 төгрөгний дэмжлэг үзүүлж 2025 оны эхний хагас жилийн байдаар Дорноговь аймгийн тамирчид тив, дэлхий, улсын чанартай тэмцээн уралдаанаас 60 алт, 70 мөнгө, 49 хүрэл медаль хүртсэн байна. Монголын хүүхдийн спортын VIII их наадамд Дорноговь аймгаас 13 төрлөөр 122 тамирчин 13 дасгалжуулагчийн хамт оролцож чөлөөт бөх 1 хүрэл, жudo бөх 1 хүрэл, модон барилдаан 1 мөнгө, бокс 1 алт, 1 мөнгө 4, шатар 1 алт, волейбол 4-р байрт шалгарч нийт 10 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.	100
ЗУРГАА: Биеийн тамир, спортын улсын хорооны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээ				
22.	Арга хэмжээ 6.1 Иргэдийн спортын төрөлжсөн наадам зохион байгуулах	Наадам зохион байгуулагдсан байх	Говийн бүсийн “Иргэдийн спортын их наадам”-ыг 05 дугаар сарын 16-18 өдрүүдэд зохион байгуулж 4 аймгийн 600 тамирчин спортын 7 төрлөөр өрсөлдлөө.	100
23.	Арга хэмжээ 6.2 Аймгийн иргэдийн дунд бүх нийтийн марафон зохион байгуулах	Марафон зохион байгуулагдсан байх	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сайншанд марафон-2025” арга хэмжээг 05 дугаар сард зохион байгуулж, уг тэмцээнд 7 наасны ангилалд 478 тамирчин оролцож 1-3 байр, багийн дүнгээр 1-3 байр эзлүүлэн 2,500,000 төгрөгийг шагналд зарцуулсан.	100
24.	Арга хэмжээ 6.3 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн”-ийг улсын хэмжээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зөв хооллолт, хорт зурсил, дасгал хөдөлгөөн, биеийн тамир, спортын арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран	Биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулагдсан байх	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан “Сайншанд марафон-2025” арга хэмжээнд 400 иргэн, Говийн бүсийн “Иргэдийн спортын их наадам”-д 4 аймгийн 600 гаруй тамирчин спортын 7 төрлөөр өрсөлдсөн. Мөн нийтийн цэнгээнт бүжгийн анхан шат, ахисан шат, шугаман бүжгийн сургалтыг НЦБ 1-р зэрэгтэй багш дасгалжуулагч О.Отгонжаргалтай хамтарч Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад шугаман бүжиг, квадрат бүжгийн сургалтыг зохион байгуулж, иргэдийн хүсэлтээр заагдсан бүжгээр тэмцээн зохион байгуулж 10 хос багийн 20 бүжгичин хамрагдсан. Шугаман бүжиг, нийтийн бүжиг, флаш моб, хийн дасгал, ажлын байрны түмэн дасгал, явган алхалт, бүх нийтийн гүйлтийг сүүлийн хагас жилд	100

	өсвөр, залуучууд, насанд хүрэгчид, ахмад, гэр бүл, ахмадын дунд зохион байгуулах		зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдсан.	
25.	Арга хэмжээ 6.4 Иргэдийн дунд Өвөл цагийн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран насны бүлгээр зохион байгуулах	Өвөл цагийн арга хэмжээг зохион байгуулагдсан байх	Өвөл цагийн арга хэмжээний хүрээнд "Мөсний баяр-2025" арга хэмжээг тус аймгийн Хөвсгөл сумын ИТХ-тай хамтран иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, цэвэр агаараар эрүүл мэндээ дэмжин ажиллаж "Мөсний биелгээ", "Буухиа тэмцээн", "Мөсний шагай тэмцээн", "Олс таталтын тэмцээн" "Чаргатай уралдаан тэмцээнүүдийг тус тус зохион байгуулж 4 баг, 5 байгууллагын 72 иргэд оролцож, 105 узэгчтэйгээр зохион байгуулсан.	100
26.	Арга хэмжээ 6.5 Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм нормативыг насны ангиллаар тогтоож мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, хичээллэх спортоор хөтөлбөр хэрэгжүүлэх	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт, /насны ангиллаар/ сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-аар үржжүүлэн хувиар тооцно.	2025 оны эхний хагас жилийн байдлаар Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох нийт сорилыг 05 дугаар сарын 05-наас аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн байгууллагын 528 иргэнээс авсан. Сорилын үр дүнд А үнэлгээтэй 19,3%, В үнэлгээтэй 35,2%, С үнэлгээтэй 27,5%, D үнэлгээтэй 18%-тай байна. Мөн А,В,С үнэлгээтэй иргэд 15.5%-ийг эзэлсэн.	70
Зорилт-7: Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх				
27.	Арга хэмжээ 7.1 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах.	Зохион байгуулсан сургалт, үйл ажиллагааны тоо	Тус газрын батлагдсан орон тоонд 59 албан хаагч ажиллаж байгаагаас 32 буюу 54,2 хувь нь эмэгтэй албан хаагч ажиллаж, 2025 онд албан тушаалд 5 албан хаагч томилогдоноы 4 буюу 80,0 хувь нь эмэгтэй албан хаагч томилогдон жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллаж байна. Ажилтан ажлын байранд жендерийн эрх тэгш нөхцөлөөр хангагдах, бэлгийн дарамтаас ангид байх, зөрчигдсөн тохиолдолд удирдлага, холбогдох байгууллагад гомдол гаргах эрхтэй талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдөн ажиллаж байна. Албан хаагчдаас жендерийн асуудалтай холбоотойгоор байгууллагын удирдлагад гаргасан санал, хүсэлт, гомдол, мэдээлэл байхгүй.	100

28.	Арга хэмжээ 7.2 Хүүхдийн эрхийг хангах талаар үйл ажиллагаа зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдагчдын тоо	Биеийн тамир, спортын газрын даргын 2022 оны А/44 дүгээр тушаалаар "Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг"-ийг батлуулан, Эцэг эхийн зөвлөлөөс төлөвлөгөө гарган ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын бага насын хүүхдийн ая тухтай байдлыг хангах, аюулгүй байлгах үүднээс хүүхдийн өрөө гарган хүүхдийн насын онцлогт тохирсон номын сан, биеийн өндөрт тохирсон ширээ сандал, бага насын хүүхэд хооллох зориулалтын ширээ сандлаар тохижуулан ажиллалаа. Мөн 0-1 насын хүүхэдтэй эхэд хүүхдээ хөхүүлэх 2 цагийг гарган өгч, ажилтан, албан хаагчдад сургууль цэцэрлэгт хүүхдээ хүргэх, авах боломжийг олгон ажиллаж байна. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Сайншанд сумын хэмжээнд хүүхэд багачуудын дунд "Сагсан бөмбөгийн алсын зайны шидэлт", "Гар дээр суниалт", "Гар барилдаан", "Буухиа" тэмцээнүүдийг зохион байгуулж 480,000 төгрөгийн шагнал гардуулж, байгууллагын албан хаагчдын 50 хүүхдүүдэд ҮЭХороотой хамтран гарын 2,500,000 төгрөгийн бэлэг гардуулан, хөгжөөнт тэмцээн зохион байгуулсан.	100
29.	Арга хэмжээ 7.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйл ажиллагааг тогтмолжуулах, татан оруулах	Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдагчдын тоо	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан тэмцээн уралдааныг сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдсан.	70
30.	Арга хэмжээ 7.4 Ахмадуудын дунд биеийн тамирын ажил үйлчилгээг үзүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдагчдын тоо	Тус газар нь ахмадуудыг биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг олгон софт волейболын 5 клубын ахмадуудыг 7 хоног бүрийн ажлын 5 өдөр 06:00-08:00, 12:00-14:00 цагуудад спорт зааланд үнэ төлбөргүй хичээллүүлж байна. Шагайн холбоотой хамтран Ахмадын шагайн харвааны тэмцээнийг зохион байгуулж 108 харваач оролцсон. Мөн Ахмадын софт волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж Улаанбаатар, Өмнөговь, Дархан-Уул, Эрдэнэт, Сүхбаатар аймгийн 160 тамирчид оролцсон.	100
31.	Арга хэмжээ 7.5 Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдлыг	Хуулийн хугацаанд хүргүүлсэн тайлан, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо	https://dornogovi.sport.gov.mn пэйж хуудсанд байгууллагын үйл ажиллагаа, секц дугуйлан, тэмцээн уралдааны талаарх мэдээллийг тухай бүр нь оруулж. Тэмцээн уралдаантай холбоотой иргэдээс ирсэн санал хүсэлт, асуултуудад хариултыг өгч ажиллаж байна.	100

	хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах		Тус газарт эхний хагас жилд 50 өргөдөл хүсэлтийг цаасаар ирүүлснээс иргэдээс ирүүлсэн хүсэлт 12 буюу 24,0 хувь, албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт 38 буюу 76,0 хувийг эзэлж, 92,0 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 4 өргөдөл шийдвэрлэх шатанд байна.	
Зорилт-8: Мэдээллийн технологийн асуудал				
32.	Арга хэмжээ 8.1 Статистикийн цахим сангийн бүрдүүлэлтийг хариуцан ажиллах	Маягтын дагуу бүрдүүлэлтийг системд байршуулсан байх	Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангаж, иргэдэд нээлттэй ил тод, тэгш хүртээмжтэй хүргэх үүднээс байгууллагын цахим хуудсыг тогтмол идэвхитэй ажиллуулж байна. Төрийн захирагааны байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа ажил, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээ мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэснээр тухайн байгууллагын цахим хуудсаны хандалтын тоо өнгөрсөн оныхоос 20 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Мөн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангаж иргэдэд олон нийтэд хүргэх үүднээс https://dornogovi.sport.gov.mn/ хаягаар дамжуулан төсөв санхүүгийн ил тод байдал, үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, тайлан төлөвлөгөө гэсэн дэд цэсүүдийг байгуулан тухайн чиглэлээр хүргэж байна.	70
33.	Арга хэмжээ 8.2 Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагдах спортын наадмуудын цахим сангийн бүрдүүлэлтийг хариуцах	Наадмын батлагдсан зааврын дагуу цахим сангийн бүрдүүлэлт хийх	Хүүхдийн спортын наадмын бүртгэлийг цахимжуулан dornogovi_soril@sport.gov.mn нэгдсэн санд 600 орчим тамирчдын мэдээллийг оруулан бүртгэлжүүлсэн.	100
34.	Арга хэмжээ 8.3 Улсын хэмжээнд зохион байгуулах сорилын арга хэмжээний цахим сангийн бүрдүүлэлтийг хийх	Сорилын аяны хүрээнд хамрагдах хүний тоо	Тус газар нь 2025 оны 05 дугаар сард 19 байгууллагын 528 иргэнээс сорилыг авч dornogovi_soril@sport.gov.mn сайтад шивсэн.	70
35.	Арга хэмжээ 8.4 Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах	Shilen.gov.mn системд байгууллагын үнэлгээ	Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлж иргэдэд https://shilen.gov.mn , https://www.facebook.com/BTSG2020 , https://dornogovi.sport.gov.mn/ цахим хуудсуудаар дамжуулан цаг үеийн мэдээ, мэдээллүүдийг хүргэж байна. Үүнд Тэмцээн уралдааны хуваарь, төсөв, санхүү, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал зэргийг тогтмол мэдээллэн ажиллаж байна.	100

			Mөн хүүхдийн спортын наадмын бүртгэлийг цахимжуулан dornogovi_soril@sport.gov.mn нэгдсэн санд тамирчдын мэдээллийг оруулан бүртгэлжүүлсэн.	
36.	Арга хэмжээ 8.5 Байгууллагын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах	Дэд хорооны төлөвлөгөөний гүйцэтгэл	Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/08 дугаартай тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган албан хаагчдыг ёс зүйн зөрчил, гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 6 удаа спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, шинээр батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ”-гээр 2 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 102 албан хаагч хамрагдаж, гарын авлага бэлтгэн албан хаагчдад өгч судлуулж байна. Эхний хагас жилийн байдлаар сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчид хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан.	70
Нийт оноо: 3330 (36 ажил, арга хэмжээ)				
Дундаж хувь: 92,5%				
Үнэлгээ 4,62				

ТАЙЛАН ГАРГАСАН:
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛООН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНТӨМӨР